



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Иххэт сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор: Э.Энхцэцэг	
		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: domogovi@audit.gov.mn

2022.02.28 № 46/211

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ИХХЭТ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГА С.ГАНЧИМЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>3,689,315.00</u>	<u>3,272,860.00</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>7,260,988.19</u>	<u>4,860,582.93</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>10,950,303.19</u>	<u>8,133,442.93</u>
	Нийт өр төлбөрийн дүн		9,645.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>10,950,303.19</u>	<u>8,123,797.93</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>10,950,303.19</u>	<u>8,133,442.93</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	63,544,900.00	61,196,934.20
	Үйл ажиллагааны зардлын дүн	60,473,623.19	62,821,534.04
	Үйл ажиллагааны үр дүн	<u>3,071,276.81</u>	<u>(1,624,599.84)</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн		<u>(1,201,905.42)</u>
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>3,071,276.81</u>	<u>(2,826,505.26)</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		
	Тайлант оны үр дүн		(2,826,505.26)
	Эцсийн үлдэгдэл		8,123,797.93
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>64,076,190.00</u>	<u>61,196,934.20</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>60,049,590.00</u>	<u>60,646,934.20</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>4,026,600.00</u>	<u>550,000.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>4,026,600.00</u>	<u>550,000.00</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		59,485,334.20
	Урсгал зардал		59,485,334.20
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		59,485,334.20
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		59,485,334.20
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Иххэт сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Эрхэм зорилго: Сумын ИТХ нь Монгол улсын хуулиудад заагдсан эрх, үүргийн биелэлтийг ханган нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх, эхэлсэн ажлуудын тогтвортой байдлыг хангахад оршино.

Алсын хараа: Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрэх үр дүн нь сумын ИТХ, хороод, ажлын алба, төлөөлөгчдийн үйл ажиллагаагаа идэвхтэй явуулах баталгаа, нөхцөлийг бий болгон ажиллуулснаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн амьдралын чухал асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрдэнэ сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх чиг үүрэг бүхий нягтлан бодогч нь тайлант хугацаанд 3 удаа өөрчлөгдсөн байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байх боловч цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10.6 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулах тухай 18 шийдвэрээс 11 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 0.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илрүүлснээс, 0.7 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Залруулсан алдаа:

Машин тоног төхөөрөмж, тавилга аж ахуйн эд хогшлын дансанд бүртгэлтэй 3.6 сая төгрөгийн өртөгтэй, 2020.12.30-ний өдөр орлогоор бүртгэсэн 2 ширхэг хөрөнгийн ашиглагдах жилийг программд оруулаагүйгээс тайлант хугацааны элэгдлийн зардлыг 0.7 сая төгрөгөөр дутуу тооцож тайлагнасныг залруулав.

Албан шаардлага:

1. Тайлант хугацаанд 0.1 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зааврын дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

2. Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10.6 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээ болон хөрөнгө зарцуулах тухай 18 шийдвэрээс 11 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.

- Мэдээллийг нөхөн байршуулж, цаашид хугацаа хоцроох, мэдээллийг байршуулахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага өгөв.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иххэт сумын ИТХ	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ									

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Иххэт сумын ИТХ	3	0.8	1	0.7	0	0	2	0.1	0	0
НИЙТ		3	0.8	1	0.7	0	0	2	0.1	0	0